



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР**

Гүйцэтгэлийн аудитын тайлан

**Уул уурхайн нөхөн сэргээлтийн хөрөнгийн
төвлөрүүлэлт, зарцуулалт, үр дүн**

**НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН БАТАЛГААНЫ
ХӨРӨНГИЙГ УРСГАЛ ЗАРДАЛД
ЗАРЦУУЛЖ ЖУРАМ ЗӨРЧСӨН БАЙНА**



Өлгий

АГУУЛГА

<u>Тайланг бэлтгэсэн:</u> Баян-Өлгий аймгийн аудитын газар Аймгийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Бекен Аудитын менежер Х.Женисбек Ахлах шинжээч К.Риза Аудитор Д.Назгүл 2015 оны 10 дугаар сар Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70422930 дугаарын утас, 70422954 дугаарын факсаар харилцана уу ХАЯГ: Аймгийн ЗДТГазрын байр 1 дүгээр давхар 102, 106 тоот өрөө	Товчилсон үгийн тайлбар 3 Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй 4 Бүлэг 1 <i>Зарим сум байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээлтийн баталгаанд байршуулсан мөнгийг төсвийн урсгал зардалд зарцуулжээ</i> - Тусгай зөвшөөрөлтэй компаниуд идвэхтэй үйл ажиллагаа явуулаагүйгээс нөхөн сэргээлтийн хөрөнгийн төвлөрүүлэлт хангалтгүй байна. - Зарим сум байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээлтийн баталгаанд байршуулсан мөнгийг төсвийн урсгал зардалд зарцуулжээ Бүлэг 2 <i>Нөхөн сэргээлт хийгдээгүй талбайн хэмжээ 2013 оноос 29 га-гаар буурсан байна.</i> - Аймгийн ИТХ, Засаг дарга, мэргэжлийн байгууллагууд уул уурхайн үйлдвэрлэл эрхэлж байгаа ААН-үүдийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт хийх үйл ажиллагаанд зохих түвшинд хяналт тавьж ажилласан байна - Нөхөн сэргээлт хийгдээгүй талбайн хэмжээ 2013 оноос 29 га-гаар буурчээ - Тусгай зөвшөөрөлтэй ААН-үүд идвэхтэй үйл ажиллагаа явуулаагүй байна Дүгнэлт..... 13 Зөвлөмж: 14 Холбогдох байгууллагын санал: 15 Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал Саналд өгсөн тайлбар
--	---

Товчилсон үгийн тайлбар		
БОАЖГ		Байгаль орчин, аялал жуулчлалын газар
АМГ		Ашигт малтмалын газар
ИТХ		Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ		Засаг даргын тамгын газар
БОНХС		Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд
БХС		Байгаль хамгаалах сан
ААН		Аж ахуйн нэгж
БОХ		Байгаль орчны хяналт
МХГ		Мэргэжлийн хяналтын газар

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудитын зорилт

Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2014 оны 20 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан “Уул уурхайн нөхөн сэргээлтийн хөрөнгийн төвлөрүүлэлт, зарцуулалт, үр дүн”-д гүйцэтгэлийн аудит хийх төлөвлөгөө, Аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторовн баталсан дэд төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу “Уул уурхайн нөхөн сэргээлтийн хөрөнгийн төвлөрүүлэлт, зарцуулалт, үр дүн”-д гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж өгөхөд энэхүү аудитын зорилт чиглэгдэв.

Хамарсан хүрээ

Энэхүү аудитад Байгаль орчныг хамгаалах, Ашигт малтмалын, Газрын хэвлийн, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулиуд, байгаль орчны болон уул уурхайн асуудал эрхэлсэн яам агентлагаас гаргасан дүрэм, журмууд болон аймаг, сумдын Засаг дарга нар болон ЗДТГазар, аймгийн БОАЖГазар, аймгийн МХГазрын 2013, 2014 онуудад уул уурхайн нөхөн сэргээлтийн талаар хийсэн ажлын тайлан, мэдээ, судалгаануудыг хамрууллаа.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглан аймаг, сумын Засаг дарга нар болон аймгийн ЗДТГазар, аймгийн БОАЖГазар, МХГазрын холбогдох албан тушаалтнуудтай ярилцах, тайлбар лавлагаа авах, хийгдсэн нөхөн сэргээлтийн ажилтай газар дээр нь очиж танилцаж баримтжуулах, ажлын тайлан мэдээ судалгаанд дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашигласны зэрэгцээ аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитын багийн бүрэлдэхүүн:

Аудитыг ахлах шинжээч К.Риза ахалж, аудитор Д.Назгүл нарын бүрэлдэхүүнтэй аудитын баг төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж, дүнг нэгтгэн, тайланг бэлтгэв.

Бүлэг 1 *Зарим сумууд байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээлтийн баталгаанд байршуулсан мөнгийг журам зөрчиж төсвийн урсгал зардалд зарцуулжээ*

Оршил

Ашигт малтмалын тухай хуулинд заасны дагуу геологи уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгуулагаас тусгай зөвшөөрөл олгож, тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүд ашигт малтмалыг эрэх, хайх, ашиглах үйл ажиллагааг явуулдаг байна.

Уул уурхайн тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж нь байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжууд болон Ашигт малтмалын тухай хуулиар хүлээсэн үүргийн хүрээнд байгаль орчныг хамгаалах талаар цогц арга хэмжээг тусгасан байгаль орчны менежментийн төлөвлөгөө болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг боловсруулж, тухайн харьяалах орон нутгийн Засаг дарга, байгаль орчны хяналтын алба, байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад тус тус хүргүүлж хянуулан батлуулдаг байна.

Тусгай зөвшөөрөл эзэмшигчээс байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгон тухайн сумын Засаг даргын нээсэн тусгай дансанд байгаль орчныг хамгаалах арга хэмжээнд шаардагдах тухайн жилийн менежментийн төлөвлөгөөнд заасан байгаль хамгаалах арга хэмжээнд шаардагдах зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг шилжүүлж, Байгаль орчныг нөхөн сэргээх арга хэмжээг бүрэн биелүүлээгүй тохиолдолд тусгай дансанд шилжүүлсэн хөрөнгөөр байгаль орчныг нөхөн сэргээх ажлыг мэргэшсэн байгууллагаар гүйцэтгүүлэн нэмж шаардагдах хөрөнгийг тусгай зөвшөөрөл эзэмшигчээс гаргуулдаг байна.

1. Уул уурхайн нөхөн сэргээлтийн хөрөнгийн төвлөрүүлэлт, зарцуулалтын талаар

Зарим сумууд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн тусгай данс нээж ажиллуулаагүй байна.

“Ашигт малтмалын тухай хууль”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс БОНХСайдын 2014 оны 04 тоот тушаалаар “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам”-ыг баталж журмын хэрэгжилтэнд зохих шатны Засаг дарга нар болон аймаг, нийслэлийн Байгаль орчны газар хяналт тавьж ажиллахыг үүрэг болгож, сумын Төрийн сангийн тусгай дансанд байршуулсан мөнгөн хөрөнгийн орлогын төвлөрүүлэлт, зарцуулалтын жилийн тайланг тухайн сумын төрийн сангийн төлөөлөгч жил

бүрийн 12 дугаар сарын 15-ны дотор ИТХ-аар хэлэлцүүлж, 12 дугаар сарын 20-ны дотор Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхээр заасан боловч Аймгийн БОАЖГазар нь сумуудын байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээлтийн тусгай данс, нөхөн сэргээлтийн хөрөнгийн төвлөрүүлэлт, зарцуулалтанд зохих журмын дагуу хяналт тавьж ажиллаагүй байна.

Сумуудын Төрийн сангийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн тусгай данстай эсэх талаар судалгааг хүснэгтээр нэгтгэн харуулвал:

№	Сумууд	Төрийн сангийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн тусгай данстай	Орон нутгийн татварын орлогын данс	Байгаль хамгаалах сан	Байгаль орчны байцаагчийн хувийн харилцах данс
1	Алтай	+			
2	Алтанцөгц	+			
3	Булган	+			
4	Бугат		+		
5	Буянт			+	
6	Дэлүүн				+
7	Ногооннуур			+	
8	Улаанхус		+		
9	Сагсай		+		
10	Толбо	+			
11	Цэнгэл		+		
	Дүн	4	4	2	1

Ашигт малтмалын тухай хуулийн 38.8.1, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9.9-д зааснаар Алтай, Булган, Толбо сумын Төрийн сан ХААН банкинд Төрийн сангийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн тусгай данс нээж нөхөн сэргээлтийн баталгааны мөнгөн хөрөнгийг байршуулсан байна. Алтанцөгц сум 2013 онд хог хаягдлын сан нэртэй дансанд нөхөн сэргээлтийн баталгааны мөнгийг байршуулж, 2014 онд байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээлтийн тусгай данс нээж баталгааны хөрөнгийг тусгаарлажээ.

Дээрхи 4 сумаас бусад сумууд хуулийн холбогдох заалтыг зөрчиж байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээлтийн баталгааны хөрөнгийг өөр бусад дансуудад байршуулсан байна. Тухайлбал: Бугат, Сагсай, Улаанхус сум байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээлтийн баталгааны мөнгөн хөрөнгийг сумын орон нутгийн татварын орлогын дансанд, Цэнгэл сум ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд, Буянт, Ногооннуур сум сумын байгаль хамгаалах сангийн дансанд, Дэлүүн сум байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээлтийн баталгааны мөнгөн хөрөнгийг сумын байгаль орчны улсын байцаагчийн Төрийн банкин дахь хувийн харилцах дансанд байршуулсан байна.

Аудитын дүнгээр Бугат, Буянт, Дэлүүн, Ногооннуур, Улаанхус, Сагсай, Цэнгэл сумуудын Засаг дарга нарт “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны хөрөнгийг байршуулах төрийн сангийн тусгай данс нээж ажиллуулах”-ыг үүрэг болгож албан шаардлага хүргүүлээ.

*Тусгай зөвшөөрөлтэй компаниуд идэвхтэй үйл ажиллагаа явуулаагүйтэй
холбоотой нөхөн сэргээлтийн хөрөнгийн төвлөрүүлэлт хангалтгүй
байна*

2013, 2014 онуудад хайгуулын тусгай зөвшөөрөлтэй 30, ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 2 аж ахуйн нэгж байгууллага үйл ажиллагаа явуулсан мэдээтэй бол байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч 52 аж ахуйн нэгж байгууллага, ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч 3 аж ахуйн нэгж байгууллага ирүүлсэн байна.

Аудитын явцад сумуудаас байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны мөнгөн хөрөнгийг төвлөрүүлсэн дансны хуулгыг авч нэгтгэж үзэхэд: 2013 онд тусгай зөвшөөрөл эзэмшигч 21 аж ахуйн нэгж байгууллагаас нөхөн сэргээлтийн баталгаанд 9,4 сая төгрөгийн, ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч 4 аж ахуйн нэгж байгууллагаас 5,8 сая төгрөгийн, 2014 онд хайгуулын зөвшөөрөлтэй 14 компаниас 5,4 сая төгрөгийн, ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 1 компаниас 7,5 сая төгрөгийн бүгд 28,4 сая төгрөгийн хөрөнгийг тухайн сумын нөхөн сэргээлтийн дансанд төвлөрүүлсэн байна.

ҮАГ-аас ирүүлсэн АМГ-ын нөхөн сэргээлтийн дансны хуулгаас тус аймагт ашиглалтын үйл ажиллагаа явуулдаг компануудыг түүвэрлэж үзэхэд 2013 онд “Юүшэнгминг” компаниас нөхөн сэргээлтийн баталгаанд 3,5 сая төгрөгийг байршуулсан байна. Бусад ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй компаниуд Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нөхөн сэргээлтийн тусгай дансанд мөнгө төвлөрүүлээгүй байна.

“Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль”-ийн 9.10-д зааснаар ашиглалтын үйл ажиллагааны төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээлтийн баталгааны мөнгийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нөхөн сэргээлтийн тусгай дансанд байршуулах ёстой боловч Ногооннуур сумын нутагт МҮ-016997 тоот ашиглалтын лицензтэй “Монголиан күүпер Майнинг” компани 0,3 сая төгрөгийн, Ү-015605 тоот лицензтэй “Юүшэнгминг” компани 0,9 сая төгрөгийн, Улаанхус суманд МҮ-011864 тоот ашиглалтын лицензтэй “Кавьернболд” ХХК 0,5 сая төгрөгийн, Цэнгэл суманд МҮ-001071 тоот лицензтэй “СС Монголиа” компани 11,6 сая төгрөгийн нийтдээ 13,3 сая төгрөгийн хөрөнгийг сумдын байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд байршуулжээ.

“Юүшэнгминг” компани МҮ-015605 тоот ашиглалтын лицензийн сумын байгаль хамгаалах сангийн дансанд нөхөн сэргээлтийн барьцаанд байршуулсан 1,9 сая төгрөгийг 2014 онд буцаан олгосон байна.

Аудитын дүнгээр Ногооннуур, Улаанхус, Цэнгэл сумын Засаг даргад байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн баталгааны дансанд ашиглалтын үйл ажиллагаа эрхэлдэг компаниудаас байршуулсан нөхөн сэргээлтийн баталгааны мөнгө болох 12,1 сая төгрөгийг Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлэхийг албан шаардлагаар үүрэг болголоо.

Зарим сумууд байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээлтийн баталгаанд байршуулсан мөнгийг төсвийн урсгал зардалд зарцуулжээ

Сумуудын байгаль хамгаалах, нөхөн сэргээлтийн сангаас 2013 онд хайгуулын тусгай зөвшөөрөлтэй 8 компанид 6,2 сая төгрөгийг, ашиглалтын лицензтэй 1 компанид 0,5 сая төгрөгийг бүгд 6,7 сая төгрөгийг, 2014 онд хайгуулын лицензтэй 6 компанид 3,6 сая төгрөгийг, ашиглалтын лицензтэй 1 компанид 1,9 сая төгрөгийг бүгд 5,5 сая төгрөгийг тус тус буцаан олгожээ.

Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд байршуулсан мөнгөн хөрөнгийг ажлын гүйцэтгэлийг харгалзан буцаан олгохдоо “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам”-ын 5.1-ийг бүрэн мөрдөж ажиллаагүй ба хяналтын хуудас хөтлөөгүй боловч сумаас томилогдсон комиссын гаргасан нөхөн сэргээлт хийгдсэн талаар актыг үндэслэж нөхөн сэргээлтийн баталгааны мөнгийг буцаан олгосон байна.

Ихэвчлэн өрөм хийх, эрэл, зураглал, маршрутын ажил зэрэг байгаль орчинд сөрөг нөлөөлөлгүй хайгуулын ажил хийсэн нөхөн сэргээлт хийгдэх шаардлагагүй гэж үзсэн зарим компаниудын нөхөн сэргээлтийн баталгаанд байршуулсан мөнгийг буцааж олгосон байна.

2014 онд Толбо сумын ЗДТГ-аас “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам”-ын 3.3-д заасны дагуу “И И Эм Хөх адар” компаны ХҮ-013275 тоот лицензийн талбайн дээж байршуулсан талбайд 1,2 сая төгрөгөөр нөхөн сэргээлтийн ажил хийлгэсэн байна.

Зарим компаниуд нөхөн сэргээлтийн буцаан олголтын мөнгөө албан тоот ирүүлж тухайн суманд зарцуулах эрхийг олгосон байна. Тухайлбал: 2013 онд “Звездаметрика” ХХК Булган суманд 1,5 сая төгрөгийг зарцуулах эрхийг олгосон, “ОАЭ” ХХК-ны саналаар 0,5 сая төгрөгийг Буянт сумын БОХ санд үлдээсэн, “Өнгөт маргад” ХХК 0,7 сая төгрөгийг сумын байгаль орчны улсын байцаагчид хөдөлмөр хамгааллын хувцас авахад хандивласан байна.

Байгаль хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны мөнгөн хөрөнгийг сумын татварын орлогын дансанд байршуулсан Бугат, Сагсай, Улаанхус сумууд баталгааны мөнгийг төсвийн урсгал зардалд зарцуулсан байна. Тухайлбал: 2013 онд Бугат сум 250,0 мянган төгрөгийг, Сагсай сум 1050,0 мянган төгрөгийг, Улаанхус сум 1100,0 мянган төгрөгийг, 2014 онд Сагсай сум 350,0 мянган төгрөгийг тус тус орон нутгийн төсвийн урсгал зардалд зарцуулжээ.

Дээрх сумууд нь Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журмын 5.5-ын “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож, тусгай дансанд байршуулсан мөнгөн хөрөнгийг энэхүү журамд зааснаас бусад зориулалтаар ашиглах, зарцуулахыг хориглоно”-гэснийг зөрчсөн байгаа тул байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны хөрөнгийг байршуулах төрийн сангийн тусгай данс нээж ажиллуулах, сумын

төсвийн урсгал зардалд зориулалт бус зарцуулсан 2250,0 мянган төгрөгийг орон нутгийн орлогын данснаас сумын төрийн сангийн нөхөн сэргээлтийн тусгай дансанд, 500,0 мянган төгрөгийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлэхээр албан шаардлага өгөгдлөө.

Аудитын дүнгээр Буянт, Ногооннуур, Сагсай, Дэлүүн, Цэнгэл, Бугат, Улаанхус сумуудад тусгай данс нээж ажиллуулах талаар болон журам зөрчсөн нийтдээ 15,0 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар албан шаардлага хүргүүлэв.

Бүлэг 2

*Нөхөн сэргээлт хийгдээгүй талбайн хэмжээ 2013 оноос
29 га-гаар буурсан байна*

2.1. Уул уурхайн нөхөн сэргээлтийн үйл ажиллагаанд тавих хяналтын талаар

Аймгийн ИТХ, Засаг дарга, мэргэжлийн байгууллагууд уул уурхайн үйлдвэрлэл эрхэлж байгаа ААН-үүдийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт хийх үйл ажиллагаанд зохих түвшинд хяналт тавьж ажилласан байна

Баян-Өлгий аймгийн нутаг дэвсгэрт 2013 оны байдлаар 46 аж ахуйн нэгж 68 хайгуулын, 15 аж ахуйн нэгж 25 ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшиж байсан бол 2014 оны байдлаар 32 аж ахуйн нэгж 45 хайгуулын, 17 аж ахуйн нэгж 25 ашиглалтын тусгай зөвшөөрлийг тус тус эзэмшиж байна.

2013 оны байдлаар хайгуулын лицензитэй аж ахуйн нэгжүүдийн эзэмшилд 761327.4 га газар, ашиглалтын лицензитэй аж ахуйн нэгжүүд 4432,68 га газрыг тус тус эзэмшиж байжээ. Харин 2014 онд хайгуулын лицензитэй аж ахуйн нэгжүүд 653830.4 га газрыг, ашиглалтын лицензитэй аж ахуйн нэгжүүд 4910.68 га газрыг тус тус эзэмшиж байгаа мэдээтэй байна.

Тусгай зөвшөөрлөөр эзэмшиж байгаа газрын хэмжээг аймгийн нийт газар нутгийн хэмжээтэй харьцуулж үзэхэд 2013 оны байдлаар нийт газар нутгийн 16.8 хувийг, 2014 онд 14.4 хувийг тусгай зөвшөөрөл эзэмшигчид уул уурхайн чиглэлээр хайгуул судалгаа хийх, олборлолт явуулах зориулалтаар ашиглаж байгаа тооцоо гарч байна.

Байгаль орчныг хамгаалах, Ашигт малтмалын, Газрын хэвлийн, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулиудад заасан эрх үүргийн хүрээнд тухайн орон нутгийн ИТХ, ЗДТГ, МХГ, БОАЖГазар болон сумдын Засаг дарга, БОХамгаалах улсын байцаагч, байгаль хамгаалагчид тухайн нутаг дэвсгэрт уул уурхайн үйлдвэрлэл эрхлэж байгаа ААНБ-дын байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт хийх үйл ажиллагаанд хууль журмын дагуу хяналт тавьж ажилласан байна.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийг хяналт шалгалтын ажилд татан оролцуулсан байна

Аймгийн ИТХ-ын дэргэд Байгаль орчин, соёл спорт аялал жуулчлалын хороог ажиллуулан уг хорооноос санаачлан АИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд аймгийн иргэдийн төлөөлөгчдийн

бүрэлдэхүүнтэй байгуулсан ажлын хэсгээр аймгийн нутаг дэвсгэрт уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт хийхээр тусган баталжээ.

Төлөвлөгөөний дагуу Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн 63 дугаар тогтоолоор тус аймагт уул уурхайн хайгуул, олборлолт явуулж байгаа ААН-ийн үйл ажиллагаанд үзлэг шалгалт явуулах ажлыг хэсгийг ИТХ-ын даргаар ахлуулан МХГ, Байгаль орчны газар, Цагдаагийн газар, Тагнуулын газар, Татварын хэлтсийн холбогдох мэргэжилтнүүд, аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн төлөөлтэй 8 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна. Тус ажлын хэсгээс шалгалтын ажил эхлэхээс өмнө тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа аж ахуйн нэгжүүдийн удирдлагуудын уулзалтыг аймгийн ЗДТГазарт зохион байгуулан 1 өдрийн сургалт семинар явуулснаас гадна компаны удирдлагуудын санал бодлыг нь сонсох, шалгалтын чиглэл удирдамжийг танилцуулах зэрэг ажлуудыг хийж уг арга хэмжээнд 41 компаны удирдлага оролцжээ.

Дээрхи ажлын хэсгээс тусгай удирдамжийн дагуу явуулсан хяналт шалгалтанд 6 сумын нутагт үйл ажиллагаа явуулж байгаа 9 ААНэгж хамрагдсан байна.

Шалгалтанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн ажлыг шалгахад тусгай зөвшөөрлийн хугацаа сунгагдсан эсэх, ААН-үүд хуулиар хүлээсэн үүргээ биелүүлсэн эсэх, менежментийн төлөвлөгөөтэй эсэх, байгаль орчны үнэлгээ хийгдсэн эсэх, эвдэрсэн газрын нөхөн сэргээлт хийгдсэн байдал, тогтмол үйл ажиллагаа явуулж байгаа эсэх, хөдөлмөрийн гэрээ болон хөдөлмөрийн эрүүл ахуй ажиллагсадын нийгмийн хамгааллын асуудал зэрэг 9 үзүүлэлтээр дүгнэсэн байна.

Шалгалтаар ашиглалтын тусгай зөвшөөрлөөр үйл ажиллагаа явуулж байгаа “СС” Монголиа, “Юүшенгминг” зэрэг компаниуд тэсрэх бодисын агуулахыг зураг төсвийн дагуу барьсан боловч мэргэжлийн байгууллагаар ашиглалтанд хүлээж аваагүй, “Лужеорд” ХХКомпани нь Ногооннуур сумын нутагт тусгай зөвшөөрөлөөр эзэмшиж байгаа 2 орд газрыг 4 жилийн турш харуул хамгаалалтгүй орхисноос иргэд хууль бусаар олборлолт хийж газрыг эвдсэн, “Сагсай минерал ресурс” ХХК-ны хайгуулын тусгай зөвшөөрлөөр эзэмшдэг Алтай сумын Хөхсүнгийн орчны хайгуулын талбайгаас тус компаны хууль бусаар алт олборлож байсан 3 карьерт нөхөн сэргээлт хийгдээгүй зэрэг байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлттэй холбоотой зөрчлүүд илэрсэн байна.

Бусад нь ААН-үүд тусгай зөвшөөрөл эзэмшдэг мөртлөө үйл ажиллагаа явуулахгүй байгаа, хөдөлмөр хамгаалал, ажилчдын цалин хөлс, хайгуул хийгдсэн талбайн зарим хэсэг нь улсын тусгай хамгаалалттай бүст орсон, ашигласан усны төлбөрөө төлөөгүй байсан, уурхайн цахилгаан хангамжтай холбоотой зөрчлүүд байсан байна.

Ажлын хэсгийн дүгнэлтийг Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдаанаар авч хэлэлцээд аймгийн Засаг даргад зарим нөхөн сэргээлт хийгээгүй компаниудад шаардлага тавьж нөхөн сэргээлт хийлгэх, эзэмшсэн талбайд үйл ажиллагаа явуулахгүй байгаа 8 компаныг

холбогдох дээд газарт уламжлан ирэх оноос үйл ажиллагаа явуулах шаардлага тавих, орон нутгийн иргэдийн хяналтыг сайжруулах, химийн бодисын ашиглалт, уурхайн ус ашиглалтанд хяналт тавих зэрэг үүрэг даалгавар өгчээ.

Аймгийн Засаг даргаас тусгай зөвшөөрөл эзэмшигч ААН-үүдийн төлөөлөгчидтэй уулзалт зохион байгуулжээ.

Аймгийн Засаг даргын 2013 оны 89 тоот захирамжаар уул уурхайн үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд аймгийн МХГазар, БОАЖГазар зэрэг байгууллагуудтай хамтран шалгалт хийж нөхөн сэргээлтийн ажлыг дутуу хийсэн “Кайнарвольфром”, “Кабернболд” ХХКомпаниудад албан шаардлага хүргүүлсэнээр Улаанхус сумын Усай хэмээх газарт 0,6 га, Ногооннуур сумын Улаан уулын ордод 0,4 га газарт техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэн хүлээлгэж өгсөн байна.

2014 оны 5 дугаар сард аймгийн Засаг дарга, ЗДТГазрын хөгжлийн бодлогын хэлтсийн дарга болон холбогдох мэргэжилтнүүд тус аймгийн нутаг дэвсгэрт хайгуул, ашиглалт хийх зориулалтаар тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа аж ахуйн нэгжүүдийн төлөөлөгчидтэй уулзалт зохион байгуулж, уул уурхайн ажлын өнөөгийн байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар мэдээлэл өгч, аймаг орон нутгийн зүгээс анхаарах асуудалд хэрхэн хамтарч ажиллах талаар ярилцсан байна. Уулзалтанд 30 тусгай зөвшөөрөл эзэмшигч, 16 аж ахуйн нэгжийн төлөөлөл оролцжээ.

Аймгийн Засаг даргын захирамжаар аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг шалгах аймгийн комиссыг байгуулан удирдамжийн дагуу Цэнгэл, Улаанхус, Ногооннуур, Буянт, Толбо, Дэлүүн, Алтай, Буянт сумдад олборлолт, хайгуул хийж байгаа компаниудын үйл ажиллагаанд шалгалт хийснээс гадна Ногооннуур сумын нутагт үйл ажиллагаа явуулж байгаа “Юүшэнгминг ХХКомпаны үйл ажиллагаанд гэнтийн шалгалт хийж илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар зөвлөмж өгч хэрэгжилтийг хангуулсан байна.

Эрсдэлтэй объектүүдийг сонгож хяналт шалгалтанд хамруулжээ

МХГазар нь Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны мөрийн хөтөлбөрт заасан “Монгол улсын газар нутагт ашиглагдаж буй орд газрын нөөцийг бүрэн ашиглаж, геологийн хайгуулын ажлын чанар үр дүнг дээшлүүлэн орд газрын нөхөн сэргээлтийг сайжруулах” зорилтыг хэрэгжүүлэхэд уул уурхайн үйлдвэрлэл эрхлэгчдэд тавих хяналтаа чиглүүлэн ажилласан байна.

2013 онд Орон нутгаас зохион байгуулсан бусад байгууллагуудтай хамтарсан хяналт шалгалтаар 2 компанид нөхөн сэргээлтийн ажлыг нөхөж хийлгэхээр албан шаардлага өгсөний дагуу 3,2 га газарт нөхөн сэргээлтийн ажил хийгджээ.

Мөн бүх сумдын Засаг дарга, БОХ-ын улсын байцаагч нар болон уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдэд орон нутагт

ашиглаж буй орд газрын нөхөн сэргээлт, тусгай дансанд байршуулсан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах, зөвшөөрөл эзэмшигчийн хуулиар хүлээсэн эрх үүргийн талаар 1 өдрийн сургалт зохион байгуулсан байна.

2014 онд МХЕГазрын 01/63 тоот удирдамж, аймгийн МХГазрын 2014 оны 29/142 тоот удирдамжийн дагуу хууль бус ашигт малтмал олборлогчид 2004-2006 онуудад ажиллаж байсан Цэнгэл сумын Ховд гол, Борбургас, Ногооннуур сумын Цүнхэгийн талбайг шалгалтанд хамруулсан байна.

Шалгалтаар “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох” журмын хэрэгжилт, нөхөн сэргээлтийн ажил стандартын дагуу хийгдсэн эсэхийг шалгаж, урьдах шалгалтаар улсын байцаагчаас өгсөн албан шаардлага, актын хэрэгжилтийг шалгаж дээрхи талбайг тусгай зөвшөөрлөөр эзэмшиж байгаа “Лужеорд” компаны, “Хайнарвольфром” ХХКомпаниудад уулын ил ажлын нөхөн сэргээгдээгүй талбай болон хууль бус ашигт малтмал олборлогчдын ухаж төнхсөн талбайн нөхөн сэргээгдээгүй 1,8 га талбайг 2014 оны 4 дүгээр сард багтаан нөхөн сэргээлт хийх талаар албан шаардлага хүргүүлсэн байна.

Мөн тухайн сум орон нутгийн удирдлагуудад дээрхи албан шаардлагын дагуу нөхөн сэргээлт хийлгэх талаар мэдэгдсэн боловч нөхөн сэргээлтийн ажил одоо болтол хийгдээгүй байна.

Хамтарсан шалгалтын дүнг иргэдэд сурталчлах, илэрсэн зөрчлүүдийг арилгуулах арга хэмжээ авчээ.

Аймгийн БОАЖГазар нь жил бүр байгаль хамгаалах төлөвлөгөө болон орон нутгийн удирдах байгууллагуудын удирдамжийн дагуу тусгай зөвшөөрлөөр ашигт малтмалын хайгуул, олборлолт эрхэлж байгаа ААНэгжүүдийн үйл ажиллагаанд хяналтаа хийж, эдгээр ААН-ийн хайгуул, олборлолтын үйл ажиллагааны байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэх эрсдэлээс хамгаалах, хайгуул, ашиглалтын явцад эвдэрсэн газар нутагт хийх нөхөн сэргээлтийг зохих журмын дагуу хийлгэх зэрэг хуулинд заасан хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллажээ.

Гэвч тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниуд БОАЖГазраас үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авдаг боловч байгаль орчны менежментийн болон байгаль хамгаалах төлөвлөгөөг зөвхөн тухайн сумын Засаг дарга, БОХ-ын улсын байцаагч нараар батлуулдагаас БОАЖГазрын мэдээллийн санд хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй холбоотой мэдээллүүд хангалтгүй байдаг байна.

2013 онд аймгийн хэмжээнд хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэг компаниудаас орон нутгийн төсөвт төлөх татвар хураамж, байгаль хамгаалах зардлын талаар иргэдэд нээлттэй мэдээлэл өгөх, хяналт тавих үүрэг бүхий зөвлөлийн бүрэлдэхүүн болон хийх ажлын төлөвлөгөөг аймгийн Засаг даргаар батлуулан хэрэгжилтийг хангуулан ажилласан байна.

Хайгуулын лицензтэй “Сагсай минерал ресурс” ХХКомпаны Алтай сумын Хөхсүм гэдэг газарт хууль зөрчиж олборлолт явуулсаны улмаас эвдэрсэн 1,7 га, “Лужеорд” компаны нөхөн сэргээлт хийгдээгүй 1,2 га газарт нөхөн

сэргээлт хийлгэхээр албан шаардлага хүргүүлсэн боловч сүүлийн 3 жилд үйл ажиллагаа явуулаагүй байгаа учир тухайн нөхөн сэргээлтийн ажил хийгдээгүй байна.

2014 онд Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 63 дугаар тогтоолын дагуу хийсэн хамтарсан шалгалтын үед илэрсэн нөхөн сэргээлттэй холбоотой зөрчлүүдийг арилгуулах, шалгалтын дүнг мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажлуудыг хийсэн байна.

Хайгуулын тусгай зөвшөөрөлтэй компаниуд хайгуулын талбай байршиж буй сумдын Засаг дарга нарт байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг хүргүүлэн батлуулан ажилладаг ба ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй компаниуд байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хувийг сумын Засаг дарга, БОХ-ын улсын байцаагч нарт ирүүлдэг байна.

Аж ахуйн нэгжүүдийн байгаль хамгаалах төлөвлөгөө, байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд заасан арга хэмжээнүүд бүрэн хийгдсэн эсэхэд сумын Засаг дарга, сумын БОХ-ын улсын байцаагчийн хамт хяналт тавьж ажилладаг байна.

Аудитын явцад 12 сумын нутаг дэвсгэрт ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэг аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаатай холбоотой судалгааг тухайн сумдын БОХ-ын улсын байцаагч нараар гаргуулан авч нэгтгэлээ. Уг судалгаанаас үзэхэд 2013 онд хайгуулын тусгай зөвшөөрөлтэй 33 аж ахуйн нэгж, 2014 онд 19 аж ахуйн нэгж байгаль хамгаалах төлөвлөгөөгөө тухайн сумдын Засаг дарга нараар батлуулан хүргүүлсэн ба 2013 онд ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 3 аж ахуйн нэгж, 2014 онд 2 аж ахуйн нэгж БОАЖЯамаар батлуулсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хувийг сумын Засаг дарга нарт ирүүлсэн байна.

Үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгжүүдийн тухайн жилд ашигласан хайгуулын ажлын талбайн нөхөн сэргээлтийг аж ахуйн нэгжүүдийн өөрсдөөр нь хийлгэж байршуулсан хөрөнгийг нь буцаасан ба 2010 онд хайгуулын ажлаа дуусгасан 1 компани ил орхигдсон дээж хураасан талбайг сумын Засаг даргын захирамжийн дагуу тус компани тусгай дансанд байршуулсан хөрөнгөөр нөхөн сэргээлт хийсэн байна. Харин ашиглалтын компаниудын хийсэн нөхөн сэргээлтийн ажлыг БОАЖГазарт уламжлан хүлээж авч байсан байна.

2.2. 2013, 2014 онуудын Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээлт хийх үйл ажиллагааны үр дүнгийн талаар

Нөхөн сэргээлт хийгдээгүй талбайн хэмжээ 2013 оноос 29 га-гаар буурчээ.

Аймгийн БОАЖГазар болон МХГазраас ирүүлсэн мэдээгээр 2013 онд 6 сумын нутагт ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч 9 ААН-ийн эзэмшилд байгаа орд газрын эвдрэлд орсон газрын хэмжээ 49,6 га газар байгаа ба үүнээс 2014 оны байдлаар нөхөн сэргээлт хийгдээгүй газрын хэмжээ 20,6 га байгаа нь 2013 оныхоос 29 га-гаар буурсан үзүүлэлттэй байна.

Уг мэдээнээс үзэхэд “Бүрkit” корпорацийн Булган сумын Индэрт-1 орд, “Сагсай минерал ресурс” ХХКомпаны Алтай сумын Энгэртийн орд, “Лужеорд” ХХКомпаны эзэмшдэг Ногооннуур сумын Бахлагын орд газрын эвдэрсэн талбайд 2013, 2014 онуудад огт нөхөн сэргээлт хийгдээгүй байгаа ба бусад ААН-үүд эвдэрсэн талбайгаа зохих хэмжээгээр жил бүр нөхөн сэргээсэн мэдээтэй байна.

Олборлолтын явцад эвдэрсэн эдгээр талбайд нөхөн сэргээлт хийгдэхгүй байгаа шалтгааныг холбогдох албан тушаалтнууд болон хамгийн их эвдэрсэн талбайтай “Бүрkit” корпорацийн удирдлага болон сумын БОХ-ын байцаагчаас тодруулахад “Индэрт-1” талбайн газар доор алтны нөөцтэй байгаа талаар зохих байгууллагын дүгнэлттэй байсан ба уг нөөцийг бүрэн ашиглаагүй байхад ордод нөхөн сэргээлт хийх боломжгүй гэсэн тайлбарыг өгч байна.

Нөхөн сэргээлт хийгээгүй 2 компанид удаа дараа албан шаардлага өгч байжээ

Харин “Лужеорд” ХХК, “Сагсай минерал ресурс” ХХКомпаниуд ямар ч шалтгаангүйгээр нөхөн сэргээлтээ хийхгүй байгаа тул аймаг орон нутгаас эдгээр компаниудад удаа дараа албан шаардлага хүргүүлж байсан байна.

2013 онд “Хайнар вольфром” ХХКомпаны эзэмшилд байгаа Ногооннуур сумын Улаан уулын орд, “Кабернболд” ХХКомпаны Улаанхус сумын Нуурын гол, “СС Монголиа” ХХКомпаны Цэнгэл сумын Ховд гол, “Түвшингарав” ХХКомпаны Алтанцөгц сумын Ямаат зэрэг 4 уурхайн орд газрын эвдэрсэн талбайн 15,1 га газарт тухайн аж ахуйн нэгжүүдийн хөрөнгөөр техникийн нөхөн сэргээлт хийж комиссын актаар хүлээлгэн өгчээ.

2014 онд “Кабернболд” ХХКомпани Нуурын голын талбайд 0,3 га, “СС Монголиа” ХХКомпани Ховд голын талбайд 5 га мөн Ховд голын уурхайн “Хайнар вольфром” ХХКомпаны эзэмшил талбайд 1,5 га, “Юүшингминг” ХХКомпани Дулаан харын талбайд 2 га нийтдээ 4 уурхайн ордын 8,8 га газарт 3 компани хөрөнгөөр техникийн нөхөн сэргээлт хийсэн бол “СС Монголиа” ХХКомпани Ховд голын талбайд 0,6 га газарт биологийн нөхөн сэргээлт хийж хүлээлгэн өгсөн мэдээтэй байна.

Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй ААНэгжүүдийн Ашигт малтмалын газарт хүргүүлсэн 2013 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөөр “Юүшингминг”, “СС Монголиа” ХХКомпаниуд нөхөн сэргээлтийн арга хэмжээ төлөвлөөгүй байсан ба “Бүрkit” корпораци 0,2 га газарт техникийн нөхөн сэргээлт, 0,7 га газарт биологийн нөхөн сэргээлтийн ажил хийхээр төлөвлөсөн байна. Тайлангаар “СС Монголиа” ХХКомпани нь 3 га газарт техникийн нөхөн сэргээлт хийж, “Бүрkit” корпораци нь тухайн жилд олборлолтын үйл ажиллагаа явуулаагүй байсан учир төлөвлөсөн нөхөн сэргээлтийн ажил хийгдээгүй байна.

2014 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд “СС Монголиа” ХХКомпани нь 1 га газарт биологийн нөхөн сэргээлт хийхээр тусгаж гүйцэтгэлээр 2 га газарт техникийн нөхөн сэргээлт, 0,6 га газарт биологийн нөхөн сэргээлт хийж хүлээлгэн өгсөн байна. Үлдсэн 0,4 га газрын биологийн

нөхөн сэргээлтийн ажлыг 2015 онд хийж өгөхөөр сумын удирдлагуудтай тохиролцсон гэсэн тайлбарыг сумын БОХ-ын улсын байцаагчаас өгч байна.

Тусгай зөвшөөрлийн дагуу 2013 онд 12 сумын нутагт 17 ААН, 2014 онд 12 сумын нутагт 13 ААНгж хайгуулын үйл ажиллагаа явуулж бүх компаниуд тухайн жилд хайгуул хийсэн талбайд малталт хийсэн, өрөм тавьсан газар болон бие засах газар, муу усны нүх зэргийг булж тэгшлэх, байрласан орчны цэвэрлэгээ хийх зэрэг нөхөн сэргээлтийн ажлыг хийж, харьяа сумын БОХ байцаагч, байгаль хамгаалагч болон байгаль орчны орон тооны бус комисст хүлээлгэн өгсөн байна.

Урьд олборлолт хийгдсэн талбайг тэгшилж үйлдвэрийн зориулалттай байр барьж ашиглажээ

Аудитын явцад Цэнгэл, Ногооннуур, Алтанцөгц, Толбо, Улаанхус сумдын нутаг дэвсгэрт хайгуул, олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн 2013, 2014 онуудад хийсэн нөхөн сэргээлтийн ажил болон ашиглалтын явцад эвдэрсэн нөхөн сэргээлт хийгдээгүй талбайтай газар дээр нь очиж танилцахад дараах байдалтай байна.

****Цэнгэл сумын Ховд голын ордод “СС Монголиа” ХХКомпани нь 2013, 2014 онуудад нийтдээ 19 га газарт техникийн нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд баяжуулах үйлдвэр шинээр баригдсантай холбоотойгоор 1990 оноос эхлэн тус ордод олборлолт хийсэн газрын нөхөн сэргээлт хийгдээгүй үлдсэн талбайг тэгшилж нөхөн сэргээлт хийж баяжуулах үйлдвэр, ажилчдын байр, тэсрэх бодисын агуулах, конторын байр, уурын зуух барих зэргээр орхигдсон талбайг нөхөн сэргээх зэрэг ажлуудыг хийжээ.**



Цэнгэл сумын Ховд голын ордод хийгдсэн нөхөн сэргээлтийн ажил

Мөн 2014 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасны дагуу үйлдвэрийн орчмын 0,6 га газарт чацарганы мод, гацуур мод, улиас, шар хуягс, хар мод, гацуур мод зэрэг нийтдээ 943 ширхэг суулгац тарьж ажилчдын байрын эргэн тойронг олон наст ургамлын үрээр зүлэгжүүлэн нөхөн сэргээлтийн ажлыг хийсэн байна.

Ногооннуур сумын “Дулаан хар”-ын орд газарт олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа “Юүшингминг” ХХКомпани нь өмнөх жилүүдийн олборлолт хийгдсэн талбайн 2 га газрыг тэгшлэн нөхөн сэргээлт хийж 2014 онд үйлдвэрлэлийн байраа өргөтгөсөн байна.



Ногооннуур сумын Дулаан харын ордод хийгдсэн нөхөн сэргээлтийн ажил

Улаанхус сумын Нуурын голын орд газрыг эзэмшиж байгаа “Кабернболд” компани нь уг ордыг өөр компаны эзэмшилд байхад нөхөн сэргээгдээгүй байсан талбайг тэгшилж, ухагдсан газрыг булах замаар 2013 онд 0,2 га, 2014 онд 0,3 га нийт 0,5 га газарт техникийн нөхөн сэргээлт хийсэн байна.

“Хайнар” вольфром ХХКомпани эзэмшиж байгаа Ногооннуур сумын Улаан уулын орд газарт урьд жилүүдийн нөхөн сэргээгдээгүй талбайн 0,6 га-д, “Түвшингарав” ХХКомпани Алтанцөгц сумын Ямаатын ордод 0,6 га газарт тус тус техникийн нөхөн сэргээлт хийжээ.

“Лужеорд” ХХКомпаны эзэмшилд байгаа Ногооннуур сумын Бахлагийн орд, “Кабернболд” ХХКомпаны эзэмшилд байгаа Улаанхус сумын Нуурын голын ордуудын нөхөн сэргээлт хийгдээгүй талбайг газар дээр нь очиж үзэхэд Нуурын голын ордод Бахлагийн орд газрын ухаж төнхсөн газарт хүн, мал орж гэмтэхээр ухсан онгорхой газар бий болж газрын хөрс их хэмжээгээр эвдэрсэн байдалтай байгаа ба тул ойрын хугацаанд нөхөн сэргээлт хийлгэх шаардлагатай байна.

Эзэнгүй орхигдсон талбай байхгүй байна.

Дээрхи эвдэрсэн нөхөн сэргээлт хийгдээгүй газруудаас эзэнгүй орхигдсон талбай байгаа эсэх талаар лавлахад нөхөн сэргээлт хийгдээгүй талбайтай орд газруудын ашиглалтын хугацаа дуусаагүй тул нөхөн сэргээгдэх боломжтой гэсэн тайлбарыг хариуцсан албан тушаалтнууд өгч байна.

Иймд гүйцэтгэлийн аудитаар одоогоор нөхөн сэргээлт хийгдээгүй, дутуу хийгдсэн 9 аж ахуйн нэгжийн эзэмшилд байгаа орд газрын нийтдээ 20,6 га газарт нөхөн сэргээлтийг хийлгэх талаар холбогдох сумын удирдлага, БОАЖГазрын холбогдох албан тушаалтнуудад зөвлөмж өгөгдөв.

2.3.Тусгай зөвшөөрөл эзэмшигч хайгуул болон ашиглалтын лицензитэй ААН-үүд хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаа талаар

Тусгай зөвшөөрөлтэй ААН-үүд идэвхтэй үйл ажиллагаа явуулаагүй байна

Ашигт малтмалын газар болон сумдаас авсан мэдээ судалгааг нэгтгэж үзэхэд 2013 онд тус аймагт хайгуулын тусгай зөвшөөрөлтэй 68 ААН байгаагаас 31 ААН хайгуулын ажлын төлөвлөгөөг, 42 ААН хайгуулын ажлын тайланг ашигт малтмалын газарт хүргүүлж, 33 ААН байгаль хамгаалах төлөвлөгөөг, 23 ААН байгаль хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийг сумдад гаргаж ирүүлсэнээс тайлант онд 16 аж ахуйн нэгж хайгуулын ажил явуулжээ.

2014 онд тус аймагт хайгуулын тусгай зөвшөөрөлтэй 45 ААН байгаагаас 17 ААН хайгуулын ажлын төлөвлөгөөг, 30 ААН хайгуулын ажлын тайланг ашигт малтмалын газарт хүргүүлж, 19 ААН байгаль хамгаалах төлөвлөгөөг, 4 ААН байгаль хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийг сумдад гаргаж ирүүлсэн байна. 2014 онд эдгээрээс 8 аж ахуйн нэгж орон нутагт хайгуулын ажил явуулсан байна.

Дээрхи мэдээ судалгаанаас үзэхэд аж ахуйн нэгжүүд төлөвлөгөө, тайлангаа батлуулдаг боловч олонхи компаниуд хайгуулын ажлаа гүйцэтгэдэггүй байна гэж үзэх үндэслэлтэй байна.

Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй ААН-ийн 8 хувь нь үйл ажиллагаа явуулж байна.

2013, 2014 онуудад ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 25 аж ахуйн нэгж байгаагаас 2013 онд 3, 2014 онд 2 аж ахуйн нэгж тус тус Ашигт малтмалын газарт уулын ажлын төлөвлөгөө, байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөө хүргүүлж, 2013 онд 2, 2014 онд 2 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулан 2013, 2014 онуудад ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн дөнгөж 8 хувь нь үйл ажиллагаагаа явуулж байсан байна.

Одоогийн байдлаар тус аймгийн Цэнгэл сумын нутагт дотоодын “СС Монголиа” компаны Ховд голын гянт болдын баяжуулах үйлдвэр үйл ажиллагаа явуулж байгаа ба Ногооннуур сумын нутагт гадаадын 100%-ийн хөрөнгө оруулалттай “Юүшингминг” ХХКомпаны Дулаанхарын хар тугалганы баяжуулах үйлдвэр үйл ажиллагаагаа түр хугацаагаар зогсоосон байна.

Аудитын явцад “СС Монголиа” компаны үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж үзэхэд Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлд заасны дагуу уурхай дээр байлгах ёстой бичиг баримтуудаа бүрэн байлгаж, хяналт хийх эрх бүхий албан тушаалтанд үйлдвэрт нэвтрэх бололцоогоор хангах, орон нутгийн байгууллагатай хамтран ажиллах талаар гэрээ байгуулан ажиллаж байгаа зэрэг Ашигт малтмалын тухай хуулинд заасан тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүргээ зохих түвшиндээ хангаж ажиллаж байгаа юм байна.

“Юүшингминг” ХХКомпаны Дулаанхарын орд одоогоор ажлаа зогсоосон уурхайн ам цоожтой, хамгаалалттай байна.

*Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй зарим компаниуд орд газраа
хамгаалалтгүй орхисон байна*

Олборлолтын үйл ажиллагаа явуулж байсан “Лужеорд” ХХК, “Кабернболд” ХХКомпаниуд орд газраа ямар ч хамгаалалтгүй эзэнгүй орхисон, “Түвшингарав” ХХКомпани Ямаат орд газар нь манаачтай боловч уурхайн амыг онгорхой хаясан, уурхай дотор ямар ч бэхэлгээ хийгдээгүй, хайгуулын ажлыг дуусгаж ашиглалтын лицензээр авсан “ОАЭ” ХХКомпани Хөх адар-1 орд газрыг эзэнгүй орхисон зэрэг тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй холбоотой зөрчлүүд аудитын явцад ажиглагдлаа.



Алтанцөгц сумын Ямаатын орд

Дээрхи байдлаар орд газрыг эзэнгүй орхисноос ялангуяа “Лужеорд”, “Кабернболд” ХХКомпаниудын эзэмшил газар нутагт иргэд хууль бус ашигт малтмал олборлож газар нутгийг сэндийчсэн байдалтай байгаа ба ууланд хууль бус ашигт малтмал олборлогчдын отог байрласан байна.



Улаанхус сумын Нуурын голын эвдэрсэн газар

Ногооннуур сумын Цүнхэгийн ордын эвдэрсэн газар

Мөн “ОАЭ” ХХКомпани Хөх адар-1 орд газарт зэргэлдээ Ховд аймгаас машинтай хүмүүс ирж шөнө оройн цагаар хууль бус олборлолт хийж байгаа талаар иргэдээс мэдээлдэг ч сумын удирдлагууд болон байгаль хамгаалагчид тэдгээр хууль бус олборлогчидтой уулзаж үйл ажиллагааг нь таслан зогсоож чадахгүй байгаа талаар тухайн сумын удирдлагууд ярьж байлаа.

Ингэж ААН-үүд хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэлгүй эзэмшсэн орд газраа хамгаалалтгүй эзэнгүй орхисон нь хууль бус ашигт малтмал олборлогчдыг бий болгож улмаар газар нутгийг эвдлэн сүйтгэх, байгаль хамгаалах асуудалд зохих хүндрэл учруулах, онгорхой орд газарт нуралт үүсэх, хүн, мал эрсдэж болох сөрөг үр дагавар гарах магадлалтай байна.

Иймд ААНэгжүүд үйл ажиллагаа явуулаагүй байсан ч орд газраа хамгаалалтандаа авах, уурхайн амыг онгорхой хаяхгүй байх, бэхэлгээ хийх, ашигт малтмалын ил илэрц байгаа газраа хамгаалах, орд газрын нөөцийг бүрэн гүйцэд ашиглах тал дээр анхаарч, үйл ажиллагаагаа тогтмолжуулан хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх шаардлагатай байна.

Ер нь ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч ихэнх компаниудын төлөөллүүд оны эхэнд орон нутагт ирж холбогдох төлөвлөгөөгөө батлуулан барьцаат хөрөнгөө байршуулсаны дараа хөрөнгө мөнгөний асуудлаас болж ажил явуулах боломжгүй байна гэсэн шалтгаанаар тусгай зөвшөөрлийн эрхээ хадгалж идэвхтэй ажил явуулахгүй, хэдэн жилийн дараа өөр хүнд орд газрыг худалдах явдал нийтлэг байгаа гэсэн тайлбарыг сум орон нутгаас өгч байна.

Аудитын дүнгээр аймгийн БОАЖГазар болон тухайн сум, орон нутгийн удирдлагуудад тусгай зөвшөөрөл эзэмшигчид орд газраа эзэнгүй орхиж хамгаалалтандаа аваагүй байгаа явдалд дүгнэлт хийж хайгуул, олборлолтын ажлыг тогтмолжуулах, илэрсэн нөөцийг гүйцэд ашиглах, эвдэрсэн газар нутгийн нөхөн сэргээлтийг хийлгүүлэх, уурхайн хэрэгцээнд ашиглаж байгаа усны эхийг хамгаалах, агаар мандалд сөрөг нөлөөлөл үзүүлэхээс сэргийлэх, байгаль орчинд нөлөөлөл багатай технологи нэвтрүүлэх талаар ашиглалтын компаниудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг зөвлөмж болгов.

Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, гүйцэтгэлийн аудитын үр дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

1.Зарим сумууд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн тусгай дансыг зохих журмын дагуу нээж ажиллуулаагүй байна.

2.Сумууд тусгай дансанд байршуулсан мөнгөн хөрөнгийн зарцуулалтын тайланг БОАЖГазарт ирүүлээгүй байна.

3.Аймгийн ИТХ, Засаг дарга, мэргэжлийн байгууллагууд уул уурхайн үйлдвэрлэл эрхэлж байгаа ААН-үүдийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт хийх үйл ажиллагаанд зохих түвшинд хяналт тавьж ажилласан байна.

4.Тусгай зөвшөөрөлтэй ААН-үүдийн эзэмшилд байгаа орд газрын хамгаалалт хангалтгүй байна.

5.Уул уурхайн үйл ажиллагаанаас эвдрэлд орсон газрын хэмжээ урьд оноос буурсан байна.

6. Тусгай зөвшөөрөлтэй ААН-үүд идэвхтэй үйл ажиллагаа явуулаагүй байна.

7. Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй компаниуд эзэмшилд байгаа орд газраа хамгаалалтандаа авахгүй бол хууль бус ашигт малтмал олборлогчид газар нутгийг эвдлэн сүйтгэх, байгаль хамгаалах асуудалд хүндрэл учруулах магадлалтай болсон байна.

Зөвлөмж

Аудитын дүн, дүгнэлтэнд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.

Аймгийн Засаг дарга Х.Дармен-д

1. Тусгай зөвшөөрөл эзэмшигчид эзэмшсэн орд газраа бүрэн хамгаалалтанд авах, нөхөн сэргээлтийн ажлыг хугацаандаа хийх, байгаль орчинд нөлөөлөл багатай технологи нэвтрүүлэх талаар уул уурхайн компаниудад шаардлага тавьж ажиллах талаар Сумын Засаг дарга нарт чиглэл өгч ажиллах;

Аймгийн БОАЖГазрын дарга Ш.Марат-д

1. Уул уурхайн олборлолтын явцад эвдэрсэн 9 аж ахуйн нэгжийн эзэмшилд байгаа 20,6 га газрын нөхөн сэргээлтийг зохих журмын дагуу хийлгэх арга хэмжээ авах;
2. Сумдын Төрийн сангаас тусгай дансны зарцуулалтын тайланг жил бүр авч, тогтмол хяналт тавьж ажиллах;
3. Тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй холбоотой мэдээлэлийн санг бүрэн бүрдүүлэх;

Холбогдох байгууллагын санал

Аймгийн ЗДТГазрын Хөгжлийн бодлогын хэлтэс болон
БОАЖГазраас ирүүлсэн санал:


**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**
83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/факс: (976) 7042-37-62


2015.11.04 № 8-03/4568
танай _____ -ны № _____ -т

АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Танай байгууллагаас уул уурхайн нөхөн сэргээлтийн хөрөнгийн төвлөрүүлэлт, зарцуулалт, үр дүнгийн талаар хийсэн шалгалтаар илэрсэн зөрчлүүдийг хүлээн зөвшөөрч байна.

Уг зөрчлүүдийн талаар холбогдох хүмүүс, компани болон сумын удирдлагуудад урьд өмнө хэлж сануулж байсан.

Цаашид уг зөрчлүүдийг гаргуулахгүй байх талаар тодорхой ажил зохиох болно.

ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА  А.БОЛАТХАН



БЮА8011

**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР**
83129 Баян-Өлгий аймаг, Өлгий сум,
Утас/факс: (976) 7042 2867

2015.11.05 № 152
танай _____ -ны № _____ -т

АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА Х.БЕКЕН ТАНАА

Тус аудитын газраас гаргасан уул уурхайн нөхөн сэргээлт, байгаль орчны хамгаалах нөхөн сэргээлтийн баталгаанд байрлуулсан мөнгөний талаар гарсан дүгнэлтийг хүлээн зөвшөөрч, зарим нэгэн алдаа дутагдлын талаар шат дараатай үйл ажиллагаа зохион байгуулан явуулахыг үүгээр мэдэгдэж байна.

ДАРГА  Х.МАРАТ


ТТЗТЗЗЗ - 9608974
БЮА8011

ТАЙЛАНГ ХЯНАЖ БАТАЛГААЖУУЛСАН:

АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Х.БЕКЕН

ТАЙЛАНГ ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР Х.ЖЕНИСБЕК

ТАЙЛАНГ БЭЛТГЭСЭН:

АХЛАХ ШИНЖЭЭЧ К.РИЗА
АУДИТОР Д.НАЗГҮЛ